



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар A/114

Мөрөн сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Рэнчинлхүмбэ сумын төвд шар усны үертэй холбогдуулан айлуудын нүхэн жорлон усанд автаж, голын усруу урсан орж, иргэдийн үндны ус бохирдох эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тул гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээ хийж, дүгнэлт гаргах, мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний тархалт, шар усны аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

С.Ганболд (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч)

Гишүүдэд:

Д.Нямбат (Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын барилгын мэргэжилтэн)
Б.Мягмарсүрэн (Аймгийн мал эмнэлгийн газрын улсын байцаагч)
М.Оюун-Эрдэнэ (Зооноз өвчин судлалын төвийн Нян судлагч эмч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Л.Нямгэрэл (Мэргэжлийн хяналтын газрын Орчны эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч)

2. Гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээг шуурхай зохион байгуулж, дүгнэлтийг, 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (С.Ганболд)-т даалгасугай.

3. Ажлын хэсгийн томилолт, техник хэрэгслийн шатах, тослох материалын тооцоог гаргаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газарт (П.Ариунбат)-т даалгасугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР